



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**ЖУУЛЧНЫ АВТОТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

MNS 5231:2003

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛЗҮЙН ТӨВ

Улаанбаатар хот

2003 он

ӨМНӨХ ҮГ

Стандарчилал, хэмжилзүйн төв (цаашид СХТ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд үндэсний стандартын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг. Тус төв нь улсын стандарт боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг юм. Техникийн хороодоор хэлэлцсэн стандартын төсөл нь СХҮЗ-ийн тогтоолоор батлагдсанаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг ДБЯ-ны Зам, тээвэр, аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Л.Энхнасан, Ё.Жаргалсайхан, Авто тээврийн газрын орлогч дарга Н.Зориг, мэргэжилтэн Б. Батбаяр, Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Х.Амарзаяа нар хамтран боловсруулсан.

Стандартын төслийг Тээврийн стандартчиллын техникийн хороо (ТХ 15), Аялал жуулчлалын стандартчиллын дэд хороо (ТХ 24/ДХ 1)-ны хурлаар тус тус хэлэлцэн зөвшилцсөн болно.

Анхны үзлэгийг 2006 онд, дараа нь 5 жил тутамд хийнэ.

Стандартчилал, хэмжилзүйн төв (СХТ):

Энх тайвны өргөн чөлөө 46А

Улаанбаатар – 211051. Ш/Х – 48

Утас: 457765, 451810 Факс (976- 1) 458032

E- mail: masm @mongolnet. Mn

© СХТ 2003

Стандарчилал, чанарын баталгаажуулалтын тухай Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХТ (Стандарчилал, баталгаажуулалтын төв байгууллагад)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага	MNS 5231: 2003
Service of tourist road transportation. General requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2003 оны 02-р сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2003 оны 04 дүгээр сарын 01-ээс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив ишлэл, нийтлэг шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

1.1 Энэхүү стандарт нь жуулчны автотээврийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтооно.

1.2 Жуулчны автотээврийн үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаа нь техникийн аюулгүй байдлыг хангасан автотээврийн хэрэгслээр жуулчдыг соёлтой, тав тухтай тээвэрлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1 Энэхүү стандарт нь жуулчны автотээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хамаарна.

2.2 Уг стандартыг жуулчны автотээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, мөн жуулчны автотээврийн үйлчилгээнд хяналт тавих эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөж хэрэглэнэ.

3 Норматив ишлэл

Энэ стандартад иш татан хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

3.1 “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага”
MNS 4598-98

3.2 “Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлт”
MNS 4599-98

3.3 “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, тодорхойлолт, ангилал, ерөнхий шаардлага” MNS 5012-2001

3.4 “Нийтийн таксийн үйлчилгээ, ангилал ба тодорхойлолт, ерөнхий шаардлага” MNS 5122:2002

MNS 5231 : 2003

3.5 “Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт” MNS 4601:98

4 Нэр томъёо, тодорхойлолт

4.1 Энэ стандартад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар ойлгоно.

4.1.1 “Жуулчин” - аялал жуулчлал хийж буй Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн.

4.1.2 “Жуулчны автотээврийн үйлчилгээ” - жуулчдын автотээврийн хэрэгслээр аяллын хөтөлбөрийн дагуу зорчих, үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа.

4.1.3 “Жуулчны автотээврийн хэрэгсэл” - жуулчин тээвэрлэхэд зориулан тусгайлан тоноглож автотээврийн хэрэгсэл.

4.1.4 “Жуулчны автотээврийн үйлчилгээ эрхлэгч” - жуулчдыг тээвэрлэх үйлчилгээг үзүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн.

5 Жуулчны автотээврийн үйлчилгээнд тавих шаардлага

5.1 Жуулчны автотээврийн үйлчилгээг “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага. MNS 4598:98” стандартын шаардлага хангасан автотээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

5.2 Автотээврийн хэрэгслийн суудалд ачаа тээвэрлэхийг хориглоно.

5.3 Ачаа, тээшийг тээшийн хонгил, ачааны хэсэгт ачих буюу дагалдан явах ачааны автомашинаар тээвэрлэнэ.

5.4 Автотээврийн хэрэгслийн бүхээг, зорчигчдын суух хэсэгт тэсэрч дэлбэрэх болон химийн бодис, зорчигчдын хувцсыг бохирдуулах, биед нь гэмтэл учруулж болох эд зүйл авч явахыг хориглоно.

5.5 Жуулчдыг аяллын үед 2 цаг тутамд түр амраах, 4.5-5 цаг тутамд хооллох үйлчилгээг үзүүлэхээр зогсолт хийнэ.

6 Жуулчны автотээврийн үйлчилгээ эрхлэгчдэд тавих шаардлага

6.1 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан байна.

6.2 Автотээврийн байгууллагын барилгын норм, дүрэм /БНБД/-ийн шаардлага хангасан дулаан гараш, автомашины ил зогсоол талбай, засвар үйлчилгээний байр бүхий автопарктай байх нөхцөлөөр хангагдсан байна.

6.3 Үйлчилгээний автотээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

6.4 Жолоочийг хариуцлагын даатгалд хамруулна.

6.5 Аяллын **чиглэл**, цагийн хуваарийг батлагдсан автозамын сүлжээг үндэслэн автотээврийн хэрэгслээр жуулчин тээвэрлэх үйлчилгээ эрхлэгч баталгаажуулна.

6.6 Жуулчны автотээврийн хэрэгслийн жолоочийн ажил, амралтын дэглэмийг “Хөдөлмөрийн тухай” Монгол Улсын хуульд нийцүүлэн зохицуулна.

6.7 Жолоочийг энгэрт зүүх нэр бүхий нэрийн хуудас, бээлий, тухайн байгууллагын билэгдлийг дүрсэлсэн ажлын хувцас, малгайгаар хангасан байна.

6.8 Тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гарах бүрт нь техникийн бүрэн байдлыг шалгаж, зөрчилтэй тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

7 Жуулчны автотээврийн хэрэгсэлд тавих шаардлага

7.1 ¹ Авто тээврийн хэрэгсэл нь авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих стандартын шаардлагыг бүрэн хангасан, **халаалт болон агааржуулалтын тохируулгатай, харилцаа холбооны хэрэгсэлтэй байх. Том оврын автобус нь тээврийн хэрэгслийн хяналтын нэгдсэн системд холбогдсон, байршил тогтоох төрөөрөмжтэй, тээшийн зориулалтын хонгилтой байна.**

7.2 Зорчигчын суудал нь толгойн түшлэгтэй, бүрээстэй, байрлалыг нь өөрчлөх тохируулагчтай байна.

7.3 Автобус нь өндөр настан, бага насны хүүхэд, жирэмсэн, нялх хүүхэдтэй эхчүүд, тахир дутуу хүмүүст зориулсан тусгай суудалтай байх бөгөөд микрофон, зорчигчдын бүхээгийн нэмэлт гэрэлтүүлэг, цонхны хөшигтэй байна.

7.4 Авто тээврийн хэрэгсэл нь урд болон ар талдаа англи, монгол хэл дээр “Tourist (Жуулчин)” гэсэн бичээс бүхий таних тэмдэгтэй байна. **Уг таних тэмдэг нь 14.8 см х 21 см хэмжээтэй, хүрээ нь оноос хамаарсан өнгөний сонголттой, хүрээний өргөн нь 1/10-тэй тэнцүү, бичээс нь цэнхэр өнгөтэй байна.**

7.5 Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээнд том, дунд, оврын автобус нь үйлдвэрлэснээс хойш 12-оос дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно.

7.6 Ашиглалтын хугацаа үйлдвэрлэснээс хойш 12 жил байна.

Жолоочид тавих шаардлага

8.1 Жолооч нь тухайн ангилалын автотээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхтэй, 3-аас доошгүй жил тээврийн хэрэгсэл жолоодсон, мэргэшсэн жолоочийн сургалт болон жуулчин тээврийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна. Тээврийн хэрэгсэлд тохиолдсон эвдрэл гэмтлийг оношлох, хөнгөн гэмтлийг засварлах чадвартай байна

8.2. Жолооч нь жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, дүгнэлт гаргуулсан байна.

8.3 Жолооч нь автотээврийн хэрэгслийн болзошгүй осол гэмтэл, саатал, байгаль цаг агаарын давагдашгүй хүчин зүйлс тохиолдохоос бусад үед аяллын хөтөлбөрийг баримтална.

8.4 Жолооч нь хөдөлгөөний үед өөрийн анхаарлыг сарниулах дуу, хөгжмийн бичлэг сонсох, тамхи татах, гар утсаар болон бусад хүмүүстэй ярих, хөтөлбөрт тусгагдаагүй бол **22.00-06.00** цагийн хооронд зорчихыг хориглоно.

¹ СХҮЗ-ийн 2006-06-29-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор “зөв талдаа хүрдтэй” гэсэн заалтыг хүчингүйд тооцов.

ТӨГСӨВ.

Стандарт, хэмжил зүйн газар

4

Стандарт, хэмжил зүйн газар.